



2018.01.23

“ХӨГЖМИЙН ЭГШИГ-2018”

хүүхдийн үндэсний хөгжмийн уралдааны удирдамж

Ерөнхий зохион байгуулагч: Говьсүмбэр аймгийн дуу бүжгийн “Боржигин” чуулга, хөгжим анги

Дэмжигч байгууллага: Монгол Улсын Соёл Урлагийн Их Сургууль, Говь Сүмбэр аймаг Боловсрол, Соёл, Урлагийн газар, Дуу Бүжгийн “Боржигин” чуулга, ГСА Сүмбэр сумын ЗДТГ, ГСА Төрийн банк

НЭГ. Уралдааны зорилго:

Ерөнхий боловсролын сургууль болон Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төвийн суралцагчдын уран сайхны мэдлэг, хөгжмийн боловсролыг дээшлүүлэх, оролцогчдын дундаас урлагийн авъяас билэгтэй сурагч, хөгжмийн багшийг тодруулж түүгээр дамжуулан хөгжмийн хөг эгшгийг үзэгч олонд хүргэх зорилготойгоор 2 жил тутамд уламжлал болгон зохиогдоно.

ХОЁР: Хамрах хүрээ

Говьсүмбэр, Дундговь, Дорноговь, Өмнөговь, Төв, Хэнтий аймгууд болон сумдын ЕБС, МСҮТ-н сурагчид

ГУРАВ: Уралдааны төрөл

Хөгжмийн уралдааныг дараах 2 төрөл, 2 үе шаттайгаар зохион байгуулагдана.

I. Хамтлаг хөгжим

Үндэсний хөгжмийн хамтлаг нь 6-12 хүний бүрэлдэхүүнтэй байх ба 1-р шатанд тоглогдсон зохиол 2-р шатанд давтагдахгүй байх.

II. Гоцлол хөгжим

Гоцлол хөгжим нь I-IV анги

V-VIII анги

IX-XII анги, МСҮТ гэсэн ангиллын дагуу явагдана.

Энэ төрлийн 1-р шатанд тоглогдох зохиол нь заавал тоглогдох нэг бүтээл, *Заавал тоглогдох зохиолыг нотны хамт хавсаргав!* өөрийн сонгосон нэг бүтээл байх ба хамсраа хөгжим ашиглаж болно. 2-р шатанд өөрийн сонгосон зохиолыг тоглоно.

Дөрөв: Шагнал урамшуулал

Хамтлаг хөгжим:

1-р байр медаль, өргөмжлөл 400.000 төг /хүүхэд бүрт медаль/

2-р байр медаль, өргөмжлөл 300.000 төг /хүүхэд бүрт медаль/

3-р байр медаль, өргөмжлөл 200.000 төг /хүүхэд бүрт медаль/

Гоцлол хөгжим: Ангилал тус бүрт

1-р байр медаль, өргөмжлөл 150.000 төг

2-р байр медаль, өргөмжлөл 100.000 төг

3-р байр медаль, өргөмжлөл 80.000 төг

Оролцогчдын чанарын үзүүлэлтээс хамаарч “Шилдэг хөгжмийн багш”-ийг тодруулна.

Шилдэг багш: цом, өргөмжлөл, 100.000 төгрөг

ЖИЧ: Ахлах насны төрөлд буюу дунд насанд оролцож байгаа шилдэг 2 хүүхдэд Соёл Урлагын Их Сургууль, Бадмаараг лице сургуульд урилгаар орох “ЭРХИЙН БИЧИГ”-р шагнана.

Тав. Хөтөлбөр

Уралдааны үйл ажиллагаа	Уралдааны хугацаа	Уралдааныг зохион байгуулах газар
Бүртгэлийн хугацаа	2018 оны 04 сарын1 дотор доорх утсаар ирүүлнэ.99608033,94750922	Говьсүмбэр аймгийн дуу бүжгийн “Боржигин” чуулга
Уралдаанд оролцогчдыг угтан авч байрлуулах	04 сарын 6-нд 15:00-18:00 цагт	Зохион байгуулагчдын байранд
Техникийн зөвлөгөөний хурал	04 сарын 6-нд 18:00 цагт	
Уралдааны 1-р шат	04 сарын 7 9:00 цагт	
Уралдааны 2-р шат	04 сарын 8 9:00 цагт	
Шагнал гардуулах ёслол	04 сарын 8	

Зургаа: Бусад

-Уралдаанд оролцогчдын бүртгэлийн мэдүүлгийг товлогдсон хугацаанд, зохион явуулах байгуулагчдын явуулсан хаягаар ирүүлэх.

-Уралдаанд оролцогчдын техникийн зөвлөгөөний хурал дээр “Хөгжмийн эгшиг-2018”уралдааны нарийвчилсан дүрмийг танилцуулах бөгөөд оролцогчдын шалгаруулалтын дэс дарааллын сугалааг явуулна.

-Уралдаанд оролцогчид нь шаардлага хангасан тоглолтын хувцас, хэрэглэл, хөгжим шуумыг ашиглаж үзүүлбэрээ толилуулна.

- Уралдаанд оролцогч хүүхэд бүрийн тоогоор мандат олгоно. Мандатын хураамж **5000** төгрөг.

Жич: Хөдөө орон нутгаас оролцож буй оролцогчид өөрсдийн зардлаар ирж уралдаанд оролцоно.

-Оролцогчид нь уралдааныг зохион байгуулахтай холбоотой бүх уулзалт, арга хэмжээний эхлэх, дуусах цагийг хатуу баримтлан идэвхи санаачлагатай, дэг журамтай оролцоно.

-Уралдааныг зохион байгуулах явцад гарсан аливаа маргаантай асуудлыг уралдааныг зохион байгуулагчид болон шүүгчид тухай бүрт нь шийдвэрлэнэ.

Уралдааны/зохион байгуулах комисс